

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өлгий хот
2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.МАРАТ ТАНАА**

2022.02.25 № 183
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,126,282.14	44,154,282.14
35	БАРАА МАТЕРИАЛ	41,126,282.14	44,154,282.14
351	Түүхий эд материал	3,608,520.50	3,678,520.50
35110	Тусгай зориулалттай материал	3,608,520.50	3,678,520.50
354	Хангамжийн материал	36,917,761.64	39,875,761.64
35410	Бичиг хэргийн материал	659,107.00	704,107.00
35420	Аж ахуйн материал	29,470,905.64	32,383,905.64
35470	Бусад хангамжийн материал	6,787,749.00	6,787,749.00
35600	Мал амьтад	600,000.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	209,039,253.22	208,256,742.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	209,039,253.22	208,256,742.30
392	Биет хөрөнгө	206,807,253.22	206,024,742.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	169,764,856.00	169,764,856.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,065,644.92)	(10,832,474.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,435,053.00	56,435,053.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(42,786,721.50)	(43,916,054.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,625,427.80	55,625,427.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,675,757.74)	(51,972,444.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,079,595.00	22,079,595.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,532,080.19)	(15,663,970.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,703,973.00	42,703,973.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,741,447.23)	(18,199,219.43)
393	Биет бус хөрөнгө	2,232,000.00	2,232,000.00
39301	Програм хангамж	1,995,000.00	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,995,000.00)	(1,995,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,232,000.00	2,232,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	250,165,535.36	252,411,024.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,107,396.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,107,396.00	-
413	Өглөг	1,107,396.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	328,000.00	-
4136	Бусад өглөг	779,396.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	779,396.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	249,058,139.36	252,411,024.44

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	249,058,139.36	252,411,024.44
51	Засгийн газрын хувь оролцоо	249,058,139.36	252,411,024.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,786,368.32	212,786,368.32
51101	Өмч: - төрийн	212,786,368.32	212,786,368.32
512	Хуримтлагдсан үр дүн	(26,384,507.00)	(23,031,621.92)
51210	Өмнөх үеийн үр дүн	(44,498,070.11)	(26,384,507.00)
51220	Тайлант үеийн үр дүн	18,113,563.11	3,352,885.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,656,278.04	62,656,278.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	250,165,535.36	252,411,024.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	593,371,398.00	555,788,018.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,526,800.00	4,383,218.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,526,800.00	4,383,218.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,638,600.00	4,383,218.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,638,600.00	4,383,218.00
120009	Бусад орлого	2,888,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	585,844,598.00	551,404,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,979,998.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,979,998.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,375,000.00	8,855,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.00	3,855,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	576,489,600.00	542,549,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	576,489,600.00	542,549,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	575,257,834.89	552,435,132.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,257,834.89	552,435,132.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,706,641.89	550,281,508.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,627,053.00	406,909,000.00
210101	Үндсэн цалин	319,789,641.00	326,054,507.00
210102	Нэмэгдэл	69,849,412.00	66,119,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,988,000.00	14,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,499,297.75	51,692,800.00
210201	Тэтгэврийн даатгал	35,188,497.75	35,416,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,077,700.00	4,069,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,262,200.00	3,255,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	815,500.00	813,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,155,400.00	8,138,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,616,418.00	12,877,908.00
210301	Гэрэл, цахилгаан	1,856,256.00	1,453,970.00
210302	Түлш, халаалт	11,302,862.00	10,888,712.00
210303	Цэвэр, бохир ус	457,300.00	535,226.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,782,588.50	4,269,645.00

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1,037,500.00	298,030.00
210402	Тээвэр, шатахуун	4,390,680.00	3,116,245.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,142,008.50	757,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,400.00	97,500.00
2105	Нормативт зардал	317,800.00	370,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	317,800.00	370,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,000.00	1,360,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000.00	50,500.00
210604	Урсгал засвар	35,000.00	1,310,000.00
2107	Томилголт, зочны зардал	1,216,000.00	1,935,602.00
210702	Дотоод албан томилолт	1,216,000.00	1,935,602.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,019,704.00	59,641,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,572,900.00	59,317,624.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	165,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	90,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,404.00	49,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	18,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,574,780.64	11,224,229.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,168,200.00	441,719.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдөл	10,406,580.64	10,782,510.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,551,193.00	2,153,624.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,808,409.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,808,409.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,742,784.00	2,153,624.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,742,784.00	2,153,624.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,113,563.11	3,352,885.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,113,563.11	3,352,885.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-26,384,507.00		249,058,139.36
C02	Нягтлан бодох үүргээний бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-26,384,507.00	0.00	249,058,139.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын таиланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гала					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-26,384,507.00	0.00	249,058,139.36
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-26,384,507.00	0.00	
D02	Нягтлан бодох үүргээний бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-26,384,507.00	0.00	249,058,139.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын таиланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гала					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			3,352,885.08		3,352,885.08
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92	0.00	252,411,024.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	589,391,400.00	555,788,018.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,526,800.00	4,383,218.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,526,800.00	4,383,218.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,638,600.00	4,383,218.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,638,600.00	4,383,218.00
120009	Бусад орлого	2,888,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	581,864,600.00	551,404,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,375,000.00	8,855,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.00	3,855,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	576,489,600.00	542,549,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	576,489,600.00	542,549,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	574,791,400.00	545,788,018.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,791,400.00	545,788,018.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,240,207.00	543,634,394.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,627,053.00	406,909,000.00
210101	Үндсэн цалин	319,789,641.00	326,054,507.00
210102	Нэмэгдэл	69,849,412.00	66,119,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,988,000.00	14,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,459,297.00	51,692,800.00
210201	Тэтгэврийн даатгал	35,148,497.00	35,416,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,077,700.00	4,069,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,262,200.00	3,255,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	815,500.00	813,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,155,400.00	8,138,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,972,600.00	13,521,726.00
210301	Гэрэл, цахилгаан	1,594,900.00	1,715,326.00
210302	Түлш, халаалт	10,920,400.00	11,271,174.00
210303	Цэвэр, бохир ус	457,300.00	535,226.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,694,553.00	4,383,742.00
210401	Бичиг хэрэг	1,037,500.00	412,127.00
210402	Тээвэр, шатахуун	4,390,680.00	3,116,245.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,053,973.00	757,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	212,400.00	97,500.00
2105	Нормативт зардал	317,800.00	440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	317,800.00	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,000.00	1,360,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000.00	50,500.00

210604	Урсгал засвар	35,000.00	1,310,000.00
2107	Томилолт, зочны зардал	888,000.00	2,263,602.00
210702	Дотоод албан томилолт	888,000.00	2,263,602.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,059,704.00	62,526,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,612,900.00	62,202,624.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	165,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	90,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,404.00	49,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	18,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,168,200.00	536,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,168,200.00	536,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,551,193.00	2,153,624.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,808,409.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,808,409.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,742,784.00	2,153,624.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,742,784.00	2,153,624.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,600,000.00	10,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,600,000.00	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,600,000.00	10,000,000.00
2200	Дотоод эх үсвэрээр	14,600,000.00	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,600,000.00	10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,600,000.00)	(10,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	546,049,800.00	544,779,394.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	546,049,800.00	544,779,394.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,049,800.00	544,779,394.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,909,000.00	406,909,000.00
210101	Үндсэн цалин	331,813,200.00	326,054,507.00
210102	Нэмэгдэл	60,360,600.00	66,119,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,735,200.00	14,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,692,800.00	51,692,800.00
210201	Тэтгэврийн даатгал	35,416,400.00	35,416,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,069,100.00	4,069,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,255,300.00	3,255,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	813,800.00	813,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,138,200.00	8,138,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,953,800.00	12,933,252.00
210301	Гэрэл, цахилгаан	1,594,900.00	1,328,900.00
210302	Түлш, халаалт	10,901,600.00	11,271,174.00
210303	Цэвэр, бохир ус	457,300.00	333,178.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,383,900.00	4,383,742.00
210401	Бичиг хэрэг	412,200.00	412,127.00
210402	Тээвэр, шатахуун	3,116,300.00	3,116,245.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,900.00	757,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,500.00	97,500.00
2105	Нормативт зардал	440,000.00	440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,500.00	100,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,500.00	50,500.00
210604	Урсгал засвар	50,000.00	50,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,993,000.00	1,993,000.00
210702	Дотоод албан томилолт	1,993,000.00	1,993,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамт	67,040,600.00	65,790,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	66,666,700.00	65,466,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	165,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,700.00	90,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,500.00	49,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,700.00	18,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	536,200.00	536,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	536,200.00	536,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	546,049,800.00	544,779,394.00
132001	Орон нутгийн төсвөөс	542,549,800.00	540,396,176.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,500,000.00	4,383,218.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	4,383,218.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	44.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41.0	44.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	35.00	30.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,375,000.00	8,855,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,375,000.00	8,855,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,375,000.00	8,855,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	588,474.00
210301	Гэрэл, цахилгаан		386,426.00
210303	Цэвэр, бохир ус		202,048.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,260,000.00
210604	Урсгал засвар		1,260,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	270,602.00
210702	Дотоод албан томилолт		270,602.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,172,000.00	6,735,924.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,172,000.00	6,735,924.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,203,000.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,203,000.00	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,375,000.00	8,855,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,375,000.00	8,855,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.00	3,855,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын хууль тогтоомжийг нутаг дэвсгэртэй хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ус цаг уур орчны шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 575.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.2 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	41126.3	44154.3	3028.0
Үндсэн хөрөнгө	209039.2	208256.7	-782.5
Нийт хөрөнгө	250165.5	252411.0	-2245.5
Өр төлбөр	1107.4	0	-1107.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	249058.1	252411.0	3352.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	250165.5	252411.0	-2245.5

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 44.1 сая төгрөг болж 3.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 13.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 10.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 208.2 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10.0 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, данс бүртгэлд тусгасан байна. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн бууралт нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1.1 сая төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулан ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 252.4 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 552.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 37.5 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилт, өөрийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 22.8 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Цалингийн зардал, нормативт зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, өмнөх оноос нэмэгдэж, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, материалын зардал, бараа материалын бусад зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны анх батлагдсан төсөв 546.0 сая төгрөг ба төсвийн тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Нийт зарлагын 542.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тусгажээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 546.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 544.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 2.1 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3.5 сая төгрөг ба гүйцэтгэлээр 4.4 сая төгрөг оруулж, 0.9 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Нийт төсвийн 74.7 хувийг цалин, 9.5 хувийг НДШ-ийн зардал, 2.3 хувийг тогтмол зардал, 12.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 1.5 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөл хэрэгжүүлэхээр 8.8 сая төгрөгийн санхүүжилт авч 6.7 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2.1 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус байгууллагын нийт санхүүжилт 542.5 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 534.8 сая төгрөгийн зардлыг хасахад 7.7 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа бөгөөд оны эцэст 2.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2021 онд нийт 555.7 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 555.7 сая төгрөгийн 142 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 9 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд итгэл үзүүлсэн тул аудитад хамрагдаагүй

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 8.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг үндэслэн аймгийн Засаг даргын 2021 оны А/438 тоот захирамж, байгууллагын даргын 2021 оны А/15 тоот тушаалаар “Ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд гүн өрмийн худаг гаргахад 6000.0 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэж, “Грин Алтан ирээдүй” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа 4800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Уг ажлын гэрээний хугацаа 2021 оны 08 дугаар сарын 20-ний өдрөөр дууссан боловч ажил нь хийгдээгүй, гэрээг дүгнээгүй байна.

2. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 194.0 мянга, хичээл үйлдвэрлэл, дадлага хийх зардлаас 98.0 мянга, нийт 290.0 мянган төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн, 3116.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлын жолоочийн тооцооны хуудаст хэрэглэсэн албан тушаалтнуудын гарын үсэг зуруулж баримтжуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-т “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх”, 350.1.6-т “захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх”, 352 дугаар зүйлийн 352.1-т “Ажил гүйцэтгэх гэрээгээр талууд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд энэ хуульд заасан нийтлэг журам үйлчилнэ”, 355 дугаар зүйлийн 355.1-т “Гэрээний аль нэг тал үүргээ ноцтой зөрчсөн бол энэ хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу нөгөө тал гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Цаашид анхаарвал зохих асуудал байхгүй

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БОАЖГазар	1	8.2					1	8.2		